



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/527

Булган сум

┌ Хяналт шалгалт зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 дахь хэсэг, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дашинчилэн сумын Хараат багийн нутагт байрлалтай МУ-16867 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Бэрхийн нурамт" ХХК-ийн Бүдүүн ухаа нэртэй алтны уурхайн үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, хууль бусаар ашигт малтмал олборлох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг хэвсралтаар баталсугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг удирдамжид заасны дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд нь хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Н.Батжаргал), Дашинчилэн сумын Засаг дарга (С.Мэнд-Амар)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР



Хамтарсан хяналт шалгалт хийх ажлын удирдамж

Нэг. Шалгалтын зорилго

Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтад хамрагдах хүрээ:

Дашинчилэн сумын Хараат багийн нутаг дэвсгэрт МУ-016867 дугаартай ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч Бэрхийн нурамт ХХК-ийн "Бүдүүн Ухаа" нэртэй алтны уурхай болон хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа иргэд, нөхөрлөл хамрагдана.

Гурав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа:

3.1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Одхүү ахална. Шалгалтын бүрэлдэхүүнд Геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Наранцацралт, Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Б.Батболд, Дашинчилэн сумын газрын даамал, татварын хяналтын улсын байцаагчид оролцоно.

3.2. Хяналт шалгалтыг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хийж гүйцэтгэх ажил

4.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн уурхай дээр байх ёстой баримт бичгийн бүрдэл, тухайн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих

4.2. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн явц, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах гэрээ, усны дүгнэлт, төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих.

4.3. Газрын гэрээ, төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих

4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартын шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах

Тав. Шалгалтын дүнг тайлагнах

5.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн зохион байгуулж тайлагнана.